



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Монголын иргэний агаарын тээвэр” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/89/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 51-260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Эрдэнэчимэг Утас: 51-261628 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Цахим хаяг: dabg.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15 № 07/423

танай _____-ны № _____-т

“МОНГОЛЫН ИРГЭНИЙ АГААРЫН
ТЭЭВЭР” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.МӨНХТАМИР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК нь үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр агаарын тээврийн түрээсийн AerCap компаниас B787-9 төрлийн 2 онгоц урт хугацааны түрээсээр ашиглах гэрээ байгуулж, эхний онгоцыг 2023 оны 8 дугаар сард хүлээн авч Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 16-д нийцүүлэн тайлагнасан байна.

Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбоотой Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 201 дүгээр тогтоолоор “Орон нутгийн нислэгийг сэргээн тогтворжуулах” шийдвэр гарч, шинэ үйл ажиллагааны чиглэл батлагдсантай холбоотой гүйцэтгэх захирлын 2023 оны А/267 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулсан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх” 10 их наядын цогц төлөвлөгөөнд тусгасан “Хуваарьт нислэг гүйцэтгэж байгаа дотоодын агаарын тээвэрлэгчдийг дэмжих зээл”-ийн хүрээнд Засгийн газрын 2022 оны 238 дугаар тогтоолоор баталсан хөнгөлөлттэй зээлд хамрагдаж хүүгийн зардал 6.4 хувиар буурсан байна.

Z:\Yawsan_Bichig\2024\0315 SNAG-30.Docx

0001051457

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 50 дугаар тогтоолоор Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Газрын тусгай үйлчилгээ, шатахууны албаны үйл ажиллагааг тус компанид шилжүүлсэнтэй холбоотой ажиллах хүчин 25 орон тоо, 61 нэрийн 6,204.4 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгө шилжин ирсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын "Орон нутгийн чиглэлд хуваарьт нислэг үйлдэх зарим арга хэмжээний тухай" 2023 оны 201 дүгээр тогтоолын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авсан байна. Үүнд:

- Гүйцэтгэх захирлын 2023 оны А/193 дугаар тушаалаар орон нутгийн, А/320 дугаар тушаалаар олон улсын нислэгийн тийзний тарифыг дунджаар 10.0-26.0 хувиар бууруулан тогтоож мөрдсөн;
- Иргэний нисэхийн үндэсний төвөөс орон нутгийн нислэгийн алдагдлыг нөхөх 8,600.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Бусад асуудлын хэсэг

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК нь 2023 онд нийт 3,377 нислэг, үүнээс 2,089 хуваарьт, 459 орон нутгийн, 614 Ханбумбат чиглэлийн захиалгат, 53 бусад захиалгат, 151 карго нислэгийг үйлдэж, 832,987.6 сая төгрөгийн орлоготой, 766,499.7 сая төгрөгийн зардалтай, 52,522.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан гэж тайлагнажээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



Z:\Yawsan_Bichigi\2024\0315 SNAG-30.Docx

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	35,059,616,094.48	20,290,815,197.34
1.1.2	Дансны авлага	23,766,034,974.99	38,173,202,856.54
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	6,275,289,400.21	17,946,555,890.09
1.1.4	Бусад авлага	2,079,855,312.72	3,151,681,159.74
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	5,000,000,000.01	27,260,732,748.70
1.1.6	Бараа материал	41,373,840,254.27	49,462,605,064.74
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	11,857,275,619.80	26,998,765,318.18
1.1.8	Эргэлтийн хөрөнгийн дүн	125,411,911,656.48	183,284,358,235.33
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	104,575,762,301.77	103,339,234,895.76
1.2.2	Биет бус хөрөнгө	10,173,954,492.64	3,829,945,400.32
1.2.3	Хойшлогдсон татварын хөрөнгө	19,642,694,860.02	20,018,150,704.87
1.2.4	Бусад эргэлтийн бус хөрөнгө	244,686,164,883.35	412,534,927,272.62
1.2.5	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	379,078,576,537.78	539,722,258,273.57
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	504,490,488,194.26	723,006,616,508.90
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	53,610,753,207.47	50,453,258,471.07
2.1.1.2	Цалингийн өглөг	132,626,027.00	1,218,378,713.00
2.1.1.3	Татварын өр	22,998,625,678.75	16,177,354,900.32
2.1.1.4	НДШ-ийн өглөг	30,344,189.73	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	46,220,459,765.19	38,204,899,993.15
2.1.1.6	Хүүний өглөг	323,467,825.52	245,484,762.83
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	7,335,111,621.42	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	55,403,697,203.87	74,084,659,275.30
2.1.1.9	Бусад богино хугацаат өр төлбөр	883,756,752.46	905,714,499.86
2.1.1.10	Богино хугацаат түрээсийн өр	20,410,634,249.90	42,355,311,909.14
2.1.1.11	Богино хугацаат өр төлбөрийн дүн	207,349,476,521.31	223,645,062,524.67
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	22,403,562,199.47	17,749,984,000.00
2.1.2.2	Бусад урт хугацаат өглөг	3,982,354,774.17	3,654,951,542.01
2.1.2.3	Урт хугацаат түрээсийн өр	195,663,755,661.15	343,420,479,194.80
2.1.2.4	Урт хугацаат өр төлбөрийн дүн	222,049,672,634.79	364,825,414,736.81
2.2	Өр төлбөрийн нийт дүн	429,399,149,156.10	588,470,477,261.48
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: а) төрийн	5,577,283,000.00	5,577,283,000.00
2.3.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	15,651,158,561.09	10,585,133,420.50
2.3.3	Эздийн өмчийн бусад хэсэг	2,376,716,050.49	2,376,716,050.49
2.3.4	Хуримтлагдсан ашиг	51,486,181,426.58	115,997,006,776.43
2.3.5	Өмнөх үеийн үр дүн	14,498,705,026.92	63,474,505,004.77
2.3.6	Тайлант үеийн үр дүн	36,987,476,399.66	52,522,501,771.66
2.3.7	Эздийн өмчийн дүн	75,091,339,038.16	134,536,139,247.42
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	504,490,488,194.26	723,006,616,508.90

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан
 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	483,160,269,423.25	814,311,570,713.07
2	Борлуулалтын өртөг	392,957,039,038.80	681,512,177,255.17
3	Нийт ашиг (алдагдал)	90,203,230,384.45	132,799,393,457.90
4	Түрээсийн орлого	58,365,828.61	56,253,733.15
5	Хүүний орлого	320,531,506.85	2,443,912,490.50
6	Бусад орлого	6,865,086,573.79	16,175,908,899.01
7	Борлуулалт, маркетингийн зардал	273,177,500.53	478,623,810.16
8	Ерөнхий ба удирдлагын зардал	20,594,057,189.51	33,988,813,595.61
9	Санхүүгийн зардал	18,330,186,758.38	28,734,434,033.70
10	Бусад зардал	9,194,014,024.33	12,864,830,765.71
11	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(6,440,439,118.59)	(8,920,854,403.06)
12	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(13,485,549.28)	-
13	Бусад ашиг (алдагдал)	(58,653.79)	-
14	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	42,601,795,499.29	66,487,911,972.32
15	Орлогын татварын зардал	5,614,319,099.63	13,965,410,200.66
16	Татварын дараах ашиг (алдагдал)	36,987,476,399.66	52,522,501,771.66
17	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	36,987,476,399.66	52,522,501,771.66
18	Орлогын нийт дүн	36,987,476,399.66	52,522,501,771.66
19	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	36,987,476,399.66	52,522,501,771.66

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,577,283,000.00	15,651,158,561.09	2,376,716,050.49	6,407,247,138.54	30,012,404,750.12
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	8,091,457,888.38	8,091,457,888.38
Залруулсан үлдэгдэл	5,577,283,000.00	15,651,158,561.09	2,376,716,050.49	14,498,705,026.92	38,103,862,638.50
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	36,987,476,399.66	36,987,476,399.66
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,577,283,000.00	15,651,158,561.09	2,376,716,050.49	51,486,181,426.58	75,091,339,038.16
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	11,988,323,578.19	11,988,323,578.19
Залруулсан үлдэгдэл	5,577,283,000.00	15,651,158,561.09	2,376,716,050.49	63,474,505,004.77	87,079,662,616.35
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(5,066,025,140.59)	-	-	(5,066,025,140.59)
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	52,522,501,771.66	52,522,501,771.66
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,577,283,000.00	10,585,133,420.50	2,376,716,050.49	115,997,006,776.43	134,536,139,247.42

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	517,163,534,557.52	850,330,810,937.29
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	516,678,875,757.46	849,330,701,270.01
1.1.2	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,215,000.00	9,223,905.60
1.1.3	Бусад мөнгөн орлого	481,443,800.06	990,885,761.68
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	451,256,536,376.35	827,244,459,345.69
1.2.1	Ажиллагчдад төлсөн	38,367,072,135.68	60,977,214,536.20
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	13,366,337,772.82	14,525,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,506,933,266.55	9,285,054,123.95
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	529,692,455.09	598,215,079.87
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	191,982,393,180.01	309,430,564,004.11
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	7,599,978,673.41	6,501,108,713.61
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	8,676,187,833.76	36,201,225,837.50
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	6,622,812,737.70	9,029,788,901.07
1.2.9	Бусад мөнгөн зарлага	182,605,128,321.33	380,696,288,149.38
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	65,906,998,181.17	23,086,351,591.60
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	296,778,082.19	2,723,686,667.36
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	799,845,472.54
2.1.2	Хүлээн авсан хүүний орлого	296,778,082.19	1,923,841,194.82
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,000,000,000.01	26,519,078,104.98
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	4,258,345,356.29
2.2.2	Хадгаламж	5,000,000,000.01	22,260,732,748.69
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,703,221,917.82)	(23,795,391,437.62)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	54,000,000,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	54,000,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	41,025,962,114.47	66,106,656,423.28
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	41,025,962,114.47	66,106,656,423.28
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(41,025,962,114.47)	(12,106,656,423.28)
4	Валютын ханшийн өөрчлөлтөө үүссэн ашиг (алдагдал)	(717,917,463.40)	(1,953,104,627.84)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	19,459,896,685.48	(14,768,800,897.14)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,599,719,409.00	35,059,616,094.48
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	35,059,616,094.48	20,290,815,197.34

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	1. Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	445.3	882.8	888.2	5.4	100.6
	1.1 Тогтмол нислэгийн зорчигч тээвэрлэлт	мян.хүн	274.6	695.6	648.3	(47.3)	93.2
	1.2 Захиалгат нислэгийн зорчигч тээвэрлэлт	мян.хүн	170.8	187.2	239.9	52.7	128.2
	2. Ачаа тээвэрлэлт (шуудан+ачаа)	тонн	7,305.9	9,987.7	9,448.9	(538.8)	94.6
	3. Зорчигч эргэлт	сая.хүн.км	997.1	2,211.5	2,256.6	45.1	102.0
	4. Ачаа эргэлт	сая.тн.км	27.4	37.8	34.5	(3.3)	91.3
	5. Шилжүүлсэн тонн-километр	сая.тн.км	132.4	264.0	251.2	(12.8)	95.2
2	6. НИЙТ ОРЛОГО	сая.төгрөг	490,407.3	838,708.7	832,987.6	(5,721.1)	99.3
	6.1 Агаарын тээврийн үндсэн үйл ажиллагааны орлого	сая.төгрөг	446,839.4	794,274.9	775,249.7	(19,025.2)	97.6
	6.2 Үндсэн бус болон үйл ажиллагааны бус орлого	сая.төгрөг	43,568.0	44,433.8	57,737.9	13,304.1	129.9
3	7. НИЙТ ЗАРДАЛ	сая.төгрөг	447,805.5	801,012.8	766,499.7	(34,513.0)	95.7
	7.1 Агаарын тээврийн үндсэн үйл ажиллагааны зардал	сая.төгрөг	428,263.2	787,016.2	739,583.2	(47,433.0)	94.0
	7.1.1 Үндсэн үйл ажиллагааны зардал	сая.төгрөг	399,727.7	748,814.4	698,267.9	(50,546.5)	93.2
	7.1.2 Ерөнхий удирдлага, нэмэгдэл зардал	сая.төгрөг	28,535.4	38,201.9	41,315.4	3,113.5	108.2
	- Ерөнхий нэмэгдэл зардлын дүн (захиргаа, удирдлага)	сая.төгрөг	17,955.9	30,197.2	33,281.8	3,084.6	110.2
	- Зээлийн хүү	сая.төгрөг	8,315.4	5,704.7	5,669.5	(35.2)	99.4
	- Үндсэн хөрөнгийн элэгдэл (агаарын хөлгөөс бусад)	сая.төгрөг	2,264.1	2,300.0	2,364.1	64.1	102.8
	7.2 Үндсэн бус болон үйл ажиллагааны бус зардал	сая.төгрөг	13,101.9	12,098.2	17,995.6	5,897.5	148.7
	Үндсэн ажиллагааны ашиг (алдагдал) валютын ханшийн алдагдлыг оруулахгүйгээр	сая.төгрөг	49,042.2	39,594.3	75,098.8	35,504.5	189.7
	7.3 Валютын ханшийн зөрүүгийн бодит олз, гарзын хэлбэлзэл	сая.төгрөг	13,337.1	2,760.8	16,139.6	13,378.9	584.6
7.4 Валютын ханшийн зөрүүгийн бодит бус олз, гарзын хэлбэлзэл	сая.төгрөг	(6,896.7)	(862.0)	(7,219.0)	(6,357.0)	837.5	
4	8. Татварын өмнөх ашиг (алдагдал)	сая.төгрөг	42,601.8	37,695.9	66,487.9	28,482.1	175.6
	- Татвар тооцогдох үйл ажиллагааны ашиг (алдагдал)	сая.төгрөг	35,705.1	36,833.5	58,959.2	28,792.0	76.4
5	9. Орлогын албан татвар	сая.төгрөг	5,614.3	8,758.4	13,965.4	5,207.0	159.5
6	10. Цэвэр ашиг (алдагдал)	сая.төгрөг	36,987.5	28,937.5	52,522.5	23,585.0	181.5

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн 527,912.9 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 2 алдаа илэрснийг залруулж санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5,258.9 сая төгрөгийн 10 зөрчил илэрснээс, авлагын бүртгэл, барилга, байгууламжийн өмчлөлтэй холбоотой нийт 5,258.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 албан шаардлага хүргүүлж, НБББББ-ийг сайжруулах, тээврийн хэрэгсэл, газрын лавлагаа, гэрчилгээ зөрүүтэй байгаа зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 5,258.9 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 8,010.1 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	НӨАТ-ын тайлангаарх нийт орлогыг Санхүүгийн үр дүнгийн тайлан, ААНБОАТ-н тайлангуудын дүнтэй зэрэгцүүлэн тулгахад 527,227.4 сая төгрөгөөр НӨАТ-ын тайланд дутуу тайлагнасан.	1	527,227.4	1	527,227.4			1	527,227.4				
	Тайлант оны татвар, санхүүгийн тайлангаарх үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын зөрүү 375.5 сая төгрөгийг тайлагнаагүй		375.5		375.5						375.5		
2	Тайлант оны худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрын үйл ажиллагаанд ачаа тээвэрлэх зориулалттай 90 ширхэг чиргүүл худалдан авч, сэлбэг хэрэгслийн дансанд бүртгэсэн	1	310.0			1	310.0	1	310.0				
Дүн		2	527,912.9	1	527,602.9	1	310.0	2	527,912.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлбэгийн дансанд бүртгэлтэй онгоцны сэлбэгийн дансны үлдэгдлийг онгоц тус бүрээр худалдан авсан жилээр нь ангилан насжилтын шинжилгээ хийхэд 275,861 ш 10,357.7 сая төгрөгийн 6-16 жилийн насжилттай сэлбэг хэрэгсэл байгаа нь нийт сэлбэгийн 35.2 хувийг эзэлж байна. НБББББ-т техникийн албанаас мөрдөх журамд нийцүүлэн нөөц бүрдүүлэх онгоцны сэлбэгийн хадгалалтын хугацааг тодорхойлоогүй, нөөц бүрдүүлэх жагсаалт байхгүй байгаа тул ашиглах боломжтой эсэхийг тодорхойлох боломжгүй.	1	-					1	-		
2	НБББББ-т Онгоцны шатахууны зардлыг бүртгэх горим, аргачлалыг дэлгэрэнгүй тодорхойлоогүй, зарцуулалтыг төлөвлөлттэй уялдуулан тайлагнахыг тусгайлан заагаагүй.	1	-					1	-		
3	НБББББ-т санхүүгийн жил зөрүүтэй, гадаад харилцагчдын санхүүгийн жилтэй хугацаа таарахгүй байгаа тооцооны авлага, өглөгийн дансдын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах горимыг тус тусад нь тодорхойлоогүй.	1	-					1	-		
4	Авлагын дансны үлдэгдэлд олон жилийн насжилттай дампуурлаа зарлаж гэрчилгээ нь гарсан 2 харилцагчийн 3,173.7 сая төгрөг, дайны нөхцөлтэй байгаа орны 1 харилцагчийн 190.6 сая төгрөг, Ковидын үеийн нислэгийн зардал 2 харилцагчийн 415.7 сая төгрөг, нийт 3,780.0 сая төгрөгийг ТУЗ-д танилцуулан шийдвэрлүүлээгүй, Шүүхийн шийдвэр гарсан 3 харилцагчийн 1,403.3 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажиллагаа удаашралтай.	1	1,403.3			1	1,403.3				
5	Авлагын дансанд бүртгэлтэй 1,446.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, олон жилийн насжилттай 12 харилцагчийн 79.0 сая төгрөгийн авлагыг хуулийн байгууллагад шилжүүлээгүй. Хэрэгжээгүй НӨАТ-ын авлага дансанд 2017-2022 онуудад үүссэн 673.2 сая төгрөгийн авлагыг тухай бүр тооцоолж тайлагнаагүй, үүссэн зөрүүг бэлтгэн нийлүүлэгч харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. Нэмэгдсэн өртгийн албан татварын авлага данснаас тохируулж бүртгэсэн 406.6 сая төгрөгийн тооцооллын задаргаа тайлбарыг ирүүлээгүй.	1	2,605.1			1	2,605.1				
6	Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Ачаа шуудангийн барилгыг 2008 онд ТӨХ-оос ИНЕГ-ын нэр дээр тогтоол гарган, барилгыг өмчлөгчид мэдэгдэлгүй буулгасан байна. Тус компаниас 2012 онд ТӨХ-нд балансаас хасах хүсэлт гаргасан, 2013 онд ЭЦГ-т гомдол гаргасан боловч аль аль нь хариу өгөөгүй, одоог хүртэл шийдвэрлэгдээгүй. Мөн байгууллагын	1	6.8			1	6.8				

	үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Увс аймгийн Улаангом сумын нутагт байршилтай Х152000284 дугаартай 1 ерөө орон сууцны барилгыг 2003 онд эзэмшигчид мэдэгдэлгүй хувь хүнд шилжүүлсэн. Шалгагдагч байгууллага нь УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагаа авч, 2023 оны 01/2673 дугаар албан бичгээр Увс аймгийн улсын бүртгэлийн хэлтэст өмчлөлийг тогтоох талаар лавлагаа хүргүүлсэн, аудитын явцад хариу ирээгүй.										
7	Авто тээврийн үндэсний төвийн лавлагааны жагсаалтад тус компанийн үндсэн хөрөнгөнд бүртгэлгүй 10 ширхэг тээврийн хэрэгсэл байгаагаас 6 нь тус компанид өмнө нь бүртгэлгүй байсан байна. Тус компанид өмнө нь бүртгэлтэй байсан 4 автомашиныг хасуулахаар Авто тээврийн үндэсний төвд 2021-2023 онд 3 удаа албан бичгээр хүсэлт гаргасан боловч хасалт хийгдээгүй.	1	-					1	-		
8	Эрхийн улсын бүртгэлийн Э-2206002630, 000012667 дугаар гэрчилгээтэй Авто баазын 13,140 м.кв газрын гэрчилгээнд Газрын кадастрын зураг болон нэгдмэл сангийн цахим системээс авсан тодорхойлолтоос 4.0 м2-р дутуу бүртгэж, 9 ба түүнээс дээш давхар орон сууцны зориулалттай гэж бүртгэгдсэн.	1	-					1	-		
9	Татваруудын ногдлын үлдэгдлийг Санхүүгийн байдлын тайлан болон татварын тодорхойлолтоор зэрэгцүүлэн тулгахад зөрүүтэй, татварын системд татварын ногдлоо тулгаж баталгаажуулаагүй.	1	-					1	-		
10	Тайлант оны худалдан авалтад мөрдсөн аргыг Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор батлагдсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмын дагуу тулган шалгахад худалдан авалтын төлөвлөгөөнд 3,380.0 сая төгрөгийн төсөвтэй 9 ширхэг худалдан авалтыг Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар хийхээр төлөвлөснөөс 1,243.7 сая төгрөгийн бараа материал, сэлбэг хэрэгслийг шууд худалдан авалтын аргаар 380 удаагийн худалдан авалт хийсэн.	1	1,243.7			1	1,243.7				
Дүн		10	5,258.9	-	-	4	5,258.9	6	-	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, Дараа жилийн төсвийн төсөл, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний нийт 182,910.8 сая төгрөгийн 3 мэдээ хугацаа хоцроосон зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлсэн.

3.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Тус байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих нийт 156 мэдээнээс 153 мэдээг хугацаанд нь оруулсан. Дараа жилийн төсвийн төсөл, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний нийт 182,910.8 сая төгрөгийн 3 мэдээ хугацаа хоцроосон.	1	182,910.8					1	182,910.8
Дүн		1	182,910.8	-	-	-	-	1	182,910.8